

ст

*Монголын Иргэний Нисэхийн Ерөнхий
Газар*

Дүрэм - 133

ИНЕГ

01 February 2016

**Нисдэг тэрэгний дүүжин
тээвэрлэлт**

Тодорхойлолт

Дүрэм-133 нь нисдэг тэрэгний дүүжин тээвэрлэлт хийх ердийн болон нислэгийн дүрэм -91 –д хийгдсэн өөрчлөлтүүдийг багтаасан болно.

Дүрэм – 133 нь спортын болон зугаа цэнгэлийн зорилгоор хүнийг нисдэг тэргэн дор дүүжин хэлбэрээр болон татлагаар тээвэрлэх үйл ажиллагаанд хамаарахгүй.

Энэ бичиг баримт нь Иргэний Нисэхийн Ерөнхий Газрын боловсруулсан дүрэм -133 –ын нэгтгэсэн шинэ хувилбар бөгөөд зөвхөн лавлагаа маягаар ашиглагдана. Энэхүү бичиг баримтыг албан хэрэгцээний дүрэм журмуудаас эмхтгэж Зам Тээврийн Яамны Сайд гарын үсэг зурж баталгаажуулсан болно. Зам Тээврийн Яамны Сайд гарын үсэг зурсан албаны дүрэм журмууд болон түүнд хийсэн засваруудын хувийг Иргэний Нисэхийн Газар болон : www.srd.mcaa.gov.mn вебсайтнаас авч болно.

Дүрмийн мэдээлэл

Энэ дүрэм нь 2001 оны 10 сарын 1-нд анх хүчин төгөлдөр болсон бөгөөд түүнээс хойш дараах засварууд хийгдсэн байна:

Засвар	Хэрэгжиж эхэлсэн хугацаа
Засвар 1 Засвар 2 Засвар 3	2010-05-07

**ИРГЭНИЙ НИСЭХИЙН ДҮРЭМ 133
НИСДЭГ ТЭРЭГНИЙ ДҮҮЖИН ТЭЭВЭРЛЭЛТ**

ГАРЧИГ

	Дэд хэсэг А Ерөнхий зүйл
133.1	Зорилго.....6
133.3	Тодорхойлолт.....6
133.5	Нисгэгчийн үнэмлэхэнд тавигдах шаардлага.....6 Дэд хэсэг
Б Үйл ажиллагааны журам, тавигдах шаардлага	
133.51	Нислэгийн хамгийн бага аюулгүй өндөр.....7
133.53	Хүн тээвэрлэх.....7
133.55	Гуравдагч этгээдийн эрсдэл.....8
133.57	Жингийн хязгаарлалт.....9
133.59	Ил харааны нислэгийн дүрэм.....9
133.61	Шөнийн нислэг.....9
133.63	Ачаа зөөвөрлөх.....9
133.65	Аюултай ачаа.....10
133.67	Үйл ажиллагааны ерөнхий шаардлага.....11
133.69	Хүн ам шигүү суурьшсан газар нутаг дээгүүрх нислэг.....11
133.71	Дүүжин хэлбэрээр хүн зөөвөрлөх.....12
133.73	Багийн нэмэлт гишүүн.....13
133.75	Нисэх багийн гишүүдийн бэлтгэл.....14
Дэд хэсэг В — Нөөц	
Дэд хэсэг Г — Нөөц	
Дэд хэсэг Д — Нөөц	
Дэд хэсэг Е — Тоног төхөөрөмж	
133.251	Зорилго.....15
133.253	Ерөнхий зүйл.....16
133.255	Дүүжин тээвэрлэлтэд ашиглах тоног төхөөрөмж.....16
133.257	Түргэн салгах хэрэгсэл.....16
Дэд хэсэг Ж — Техник үйлчилгээ	
133.301	Зорилго.....17
133.303	Техник үйлчилгээнд тавих шаардлага.....17
133.305	Техник үйлчилгээний ажилтан.....17
133.307	Гадна хэрэгсэл.....17

А БҮЛЭГ - ЕРӨНХИЙ ЗҮЙЛ 133.1

133.1 Зорилго

(а) Нисдэг тэргээр хүн ба ачааг дүүжин хэлбэрээр өргөх, буулгах, зөөвөрлөх ажиллагааг ИНД-91-ийн заалтуудад нийцүүлэн зохицуулахад энэ дүрмийн зорилго оршино.

(б) Энэ дүрэм нь нисдэг тэргээр спорт, зугаа цэнгээний зорилгоор дүүжин хэлбэрээр хүн зөөвөрлөх үйл ажиллагаанд хамаарахгүй.

133.3. Тодорхойлолт

Нисдэг тэрэгний дүүжин тээвэрлэлт гэдэгт-

- (1) Нисдэг тэргээр дүүжин ачааг татлагын тавцант төхөөрөмжид байрлуулан чирэх үйл ажиллагаа; эсвэл
- (2) Нисдэг тэргээр дүүжин ачааг гогцоот татлага ашиглан зөөвөрлөх ажиллагаа; эсвэл
- (3) Нисдэг тэргээр дамартай зөөлөн холбоос ашиглан хүн тээвэрлэх үйл ажиллагаа; эсвэл
- (4) Нисдэг тэргээр гогцоот олс ашиглан хүн тээвэрлэх зэрэг үйл ажиллагааг хамруулж ойлгоно.

Нисдэг тэргээр дүүжин тээвэрлэлтийг татлагын тавцан ашиглан хийх үйл ажиллагаа гэдэгт дүүжин ачааг татлагын тавцанд байрлуулан чирэх, доошлуулах, газарт буулгах үйл ажиллагааг ойлгох бөгөөд тухайн үйл ажиллагааны үед ачаа газартай харьцсан хэвээр байна.

Нисдэг тэргээр дүүжин тээвэрлэлтийг татлага ашиглан зөөвөрлөх үйл ажиллагаа гэдэгт ачаа, карго болон хүн буулгах, өргөх үйл ажиллагаанд сагс, тор, тоноглол, татлага, дамнуурга ашиглан нисдэг тэрэгний дор унжуулж тээвэрлэх үйл ажиллагааг ойлгоно.

OGE - Газрын нөлөө байхгүй (товчлол)

133.5. Нисгэгчийн үнэмлэхэнд тавигдах шаардлага.

(а) Нисдэг тэргээр дүүжин тээвэрлэлт гүйцэтгэх агаарын хөлгийн дарга нь:

- (1) коммерийн нисгэгчийн хүчин төгөлдөр үнэмлэхтэй (нисдэг тэрэгний) байна, эсвэл
- (2) хувийн нисгэгчийн хүчин төгөлдөр үнэмлэхтэй (нисдэг тэрэгний)байх ба үүнд татлагат дүүжин ачааг тээвэрлэх сургалтыг ИНД-61.153 дагуу амжилттай дүүргэсэн талаар багш нисгэгч нислэгийн дэвтэрт нь тэмдэглэл хийсэн байх шаардлагатай.

(б) Хөдөлгөөнт зөөлөн холбоос ашиглан хүн өргөх, буулгах болон гогцоот олс ашиглан хүн буулгах, эсхүл дүүжин хэлбэрээр хүн зөөвөрлөх ажиллагаа гүйцэтгэх

агаарын хөлгийн дарга нь энэ зүйлийн (а) (2)-т заасныг үл харгалзан коммерийн нисгэгчийн хүчин төгөлдөр үнэмлэхтэй (нисдэг тэрэгний) байна.

(в) Коммерийн, эсвэл хувийн нисгэгчийн хүчин төгөлдөр бус үнэмлэхтэй нисгэгч сургалтанд хамрагдаж байх үедээ багш нисгэгч зөвшөөрсөн тохиолдолд энэ зүйлийн (а), (б)-д заасныг үл харгалзан дүүжин тээвэрлэлтийн сургалтын нислэгийг агаарын хөлгийн даргаар гүйцэтгэж болно.

Б БҮЛЭГ - ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ, ШААРДЛАГА

133.51. Нислэгийн хамгийн бага аюулгүй өндөр

(а) Дүүжин тээвэрлэлт гүйцэтгэж буй агаарын хөлгийн дарга нь шаардлагатай гэж үзвэл газар дээрх хүн болон эд хөрөнгөд аюул учруулхааргүй арга хэмжээ авсан тохиолдолд ИНД-91-ийн холбогдох заалтыг үл харгалзан, газрын гадаргуугаас дээш 150 м (500 фут)-ээс бага өндөрт хүн, усан онгоц, тээврийн хэрэгсэл, барилга байгууламжинд 150 м (500 фут)-ээс дотогш зайд ойртох, хөөрөх, ачаа байрлуулах ажиллагааг гүйцэтгэж болно.

(б) Дүүжин тээвэрлэлт гүйцэтгэж буй агаарын хөлгийн дарга нь онцгой тохиолдолд дүүжин ачааг нисдэг тэрэгнээс салгаж хаях болон буулт үйлдэхэд тохиромжтой нислэгийн өндөр, чиглэлийг газар дээрх хүн болон эд хөрөнгөд аюул учруулахгүйгээр үндэслэлтэй тогтоох үүрэгтэй.

133.53. Хүн тээвэрлэх

(а) Агаарын хөлгийн дарга нь нисдэг тэргээр гадна ачаа чирэх ажиллагаа үйлдэх үед тухайн ажиллагаанд шаардлагатай үүрэг гүйцэтгэхгүй этгээдийг нисдэг тэргэн дотор тээвэрлэж болохгүй.

(б) Агаарын хөлгийн дарга нь бэхэлгээт олсоор дүүжин ачаа тээвэрлэх үед тухайн ажиллагаанд шаардагдах үүрэг гүйцэтгэхгүй этгээдийг хэрэв:

(1) бэхэлгээт олсоор хүн тээвэрлэх ажиллагаа биш бол

(2) тухайн этгээд ачааг буулгах газарт тухайн ажиллагаатай шууд холбоотой үүрэг гүйцэтгэхгүй бол

(3) тухайн ажиллагааны аюулгүй байдалд нөлөөлөх бол нисдэг тэргэн дотор тээвэрлэж болохгүй.

(в) Агаарын хөлгийн дарга нь дамарт татлагаар болон бэхэлгээт олсоор хүн тээвэрлэх, эсвэл гогцоот олсоор хүн тээвэрлэх ажиллагааны үед эдгээр ажиллагаанд шууд үүрэг гүйцэтгэхгүй этгээдийг нисдэг тэргэн дотор тээвэрлэхгүй.

(г) Гадна ачаа тээвэрлэх ажиллагаанд үүрэг гүйцэтгэхгүй, нислэгийн бүхээгт дадлага хийж байгаа багийн гишүүнийг агаарын хөлгийн дарга (а) (б) (в) заалтуудыг үл харгалзан дараах тохиолдлуудад нисдэг тэргэн дотор тээвэрлэж болно:

(1) агаарын хөлгийн дарга багийн гишүүнийг тухайн төрлийн ажиллагаанд сургах эрх олгогдсон тохиолдолд;

- (2) нислэгийн аюулгүй байдалд нөлөөлөхгүй тохиолдолд

133.55. Гуравдагч этгээдийн эрсдэл

(а) Агаарын хөлгийн дарга дараах тохиолдлуудад нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэж болохгүй:

- (1) хэрэв тухайн хүн зөвшөөрөл өгөөгүй тохиолдолд аливаа хувь хүн болон хувь хүний өмч хөрөнгөд аюул учруулахаар байвал;
- (2) задгай талбайд олон хүн цугларсан газарт

(б) (в) заалтад дурьдсанаас бусад тохиолдолд дүүжин ачаа тээвэрлэж агаарт хөдөлгөөнгүй байрлалд нисдэг тэргийг байрлуулж байгаа агаарын хөлгийн дарга тухайн газарт хүн байгаа эсэхийг магадлах ёстой. Үүнд ачааг буулгах ажиллагаанд оролцох үүрэг хүлээсэн хүмүүс хамаарахгүй бөгөөд тэдгээр хүмүүст тухайн ажиллагааны талаар дараах зүйлүүдийг танилцуулсан байх шаардлагатай:—

- (1) дүүжин ачаа тээвэрлэхэд мөрдөх журмууд;
- (2) онцгой байдлын үед бүх ажилчдын мөрдөх журам;
- (3) дүүжин ачааны онцлог, түүнтэй харьцахад тавигдах шаардлагууд;
- (4) нисдэг тэргний өргөлт хийх чадал;
- (5) ажиллагааны үед хэрэглэгдэх гар болон радио дохио.

(в) Газарт бэртэж гэмтсэн хүмүүст тусламж үзүүлж байгаа тохиолдолд (б) заалтыг мөрдөх шаардлагагүй.

133.57. Жингийн хязгаарлалт

Дүүжин тээвэрлэлт гүйцэтгэх үед ачааны жинг энэ дүрмийн 133.255-ын (1)-д заасан өргөх дэгээ буюу төхөөрөмжийн жингийн хэмжээнээс хэтрүүлэхгүй байхыг агаарын хөлгийн дарга хариуцна.

133.59. Ил харааны нислэгийн дүрэм

Дүүжин тээвэрлэлт гүйцэтгэх агаарын хөлгийн дарга нь нислэгийг ил харааны нислэгийн дүрмээр гүйцэтгэнэ.

133.61. Шөнийн нислэг

Агаарын хөлгийн дарга нь нисдэг тэрэг, газар болон тэнгэрийн гэрэлтүүлэгт тусах гадны биетийн баримжаагаар нисдэг тэргний харьцангуй байршил, байрлал, өндрийг тодорхойлох боломжгүй бол шөнийн цагт дүүжин тээвэрлэлтийн нислэг үйлдэж болохгүй.

133.63. Ачаа зөөвөрлөх

Агаарын хөлгийн дарга нь энэ дүрмийн 133.255-ын (1)-д заасан өргөх дэгээ, хэрэгслийг ашиглан дүүжин ачаа өргөгдөж байгаа эсэхийг нягтална.

133.65. Аюултай ачаа

(а) Агаарын хөлгийн дарга дараах тохиолдолд ИНД-92-ыг үл харгалзан, нисдэг тэргээр 1-р ангиллын аюултай ачааг дүүжин хэлбэрээр зөөвөрлөж болно:

- (1) ИНЕГ-ын эрх бүхий байцаагч зөвшөөрсөн тохиолдолд;
- (2) тухайн ачаа зөөвөрлөлтийг зохицуулах аюулгүй ажиллагааны болон онцгой тохиолдлын журам ашиглагдаж байгаа тохиолдолд.
- (3) тухайн аюултай ачаа нь:
 - (i) агаараар зөөвөрлөх зохих нөхцлөөр хангагдсан тохиолдолд,
 - (ii) зөөвөрлөхөд аюулгүй байхаар баглаж, аюулгүй байдлыг хангасан тохиолдолд.
- (4) тухайн ажиллагааг хот суурины хүн ам шигүү суурьшсан газар нутгаас алслагдсан зайд гүйцэтгэх нөхцөлд.

(б) Агаарын хөлгийн дарга дараах тохиолдолд ИНД-92-ыг үл харгалзан, нисдэг тэргээр 2-9 дүгээр ангиллын аюултай ачааг дүүжин хэлбэрээр зөөвөрлөж болно:

- (1) тухайн аюултай ачааны техник ажиллагааны зааварт зөөвөрлөхийг хориглоогүй нөхцөлд;
- (2) тухайн ачааг зөөвөрлөхөд шаардагдах аюулгүй ажиллагааны болон онцгой тохиолдлын журамтай тохиолдолд;
- (3) аюултай ачаа бүр таних тэмдэгтэй бол;
- (4) агаарын хөлгийн дарга нь ачааны аюултай шинж чанарын тухай танилцуулга хийгдсэн тохиолдолд;
- (5) аюултай ачаа нь:
 - (i) агаараар зөөвөрлөх зохих нөхцлийг хангасан бол;
 - (ii) өөр хоорондоо урвалд орох ачааг ялгаж тусгаарласан бол;
 - (iii) нислэгийн явцад гэмтэх, асгарахаас сэргийлсэн баглаа, боодолтой бол.

133.67. Үйл ажиллагааны ерөнхий шаардлага

(а) Дүүжин тээвэрлэлт гүйцэтгэх агаарын хөлгийн дарга нь нисдэг тэрэг ачаалалтын талбайгаас хөөрөхөөс өмнө ачааг зөв байрлуулж, бэхэлсэн эсэхийг хянана.

(б) Дүүжин тээвэрлэлт гүйцэтгэх агаарын хөлгийн дарга нисдэг тэрэг болон дүүжин ачааг удирдаж, хянахад тохиромжтой тохиолдолд нислэгийг үйлдэнэ.

133.69. Хүн ам шигүү суурьшсан газар нутаг дээгүүрх нислэг

(а) Хүн ам шигүү суурьшсан газар нутаг, хот, суурин дээгүүр дүүжин тээвэрлэлт гүйцэтгэх агаарын хөлгийн дарга:

(1) дараах зүйлсийг багтаасан ажлын төлөвлөгөөг тухайн ажиллагаанд оролцох бүх байгууллага, хүмүүсийг оролцуулан боловсруулж танилцуулсан байна:

(i) нислэгийн чиглэл ба өндрийг заасан зураглал;

(ii) нислэгийн саадаас зайлсхийх арга зам;

(iii) онцгой тохиолдлын үед хийх ажиллагааны тодорхой төлөвлөгөө;

(iv) онцгой тохиолдолд ачааг зориудаар салгах болон ачаа санамсаргүй салах үед газарт байгаа хүн болон эд зүйлсэд аюул учруулахгүй байхад чиглэсэн арга хэмжээ;

(v) нислэгийн хөдөлгөөний үйлчилгээний зохицуулалт

(2) энэ зүйлийн (1)-д заасан ажлын төлөвлөгөөг тухайн ажиллагааг гүйцэтгэсэн өдрөөс хойш 6 сараас доошгүй хугацаагаар хадгална;

(3) нутгийн захиргааны байгууллагад бичгээр урьдчилан мэдэгдэнэ;

(4) нутгийн захиргааны байгууллагын аливаа шаардлагыг биелүүлнэ;

(5) явуулах гэж буй ажиллагааныхаа тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд мэдээлнэ.

133.71. Дүүжин хэлбэрээр хүн зөөвөрлөх

(а) Нисдэг тэрэгний дүүжин хэлбэрийн тээвэрлэлтээр хүн зөөвөрлөх агаарын хөлгийн дарга дараах шаардлагыг хангуулсан байна:

(1) нислэгийг, газрын үйлчлэлийн нөлөөгүй дүүжин нислэг үйлдэх үеийн тооцоот жингийн 90 хувиас хэтэрсэн жинтэй гүйцэтгэхгүй байх;

(2) хүн зөөвөрлөх зай нь тухайн ажиллагааг гүйцэтгэхэд шаардлагатай хамгийн богино зай байх;

(3) хүн өргөх, буулгах, зөөвөрлөх хэрэгсэл нь хоёр тусдаа үйлдлээр нисдэг тэрэгнээс салгагдах системтэй байх ба нисэх багийн гишүүн салгах боломжтой байх;

- (4) хүн өргөж, зөөвөрлөх хэрэгсэл нь болгоомжгүй үйлдлийн улмаас салах боломжгүй байх;
- (5) нисдэг тэрэгний жолоодлогыг аюулгүй гүйцэтгэхийн тулд
- (i) диаметрийн хэмжээ нь нисдэг тэрэгний нийт уртыг 2 дахин авсан хэмжээнээс багагүй байна.
 - (ii) нисдэг тэрэгний хамгийн доод цэгээс доош босоо тэнхлэгт 1 метрийн зайд ямар нэг саад байхгүй байх;
 - (iii) хүн өргөх, буулгах, зөөвөрлөх орчин нь тухайн ажиллагаа явуулахад саадгүй байх.
- (б) Агаарын хөлгийн дарга нисдэг тэрэгнээс хөдөлгөөнт зөөлөн холбоос ашиглан хүн өргөх, буулгахдаа дараах зүйлсийг нягталсан байна:
- (1) хүн доош буулгах тохиолдолд суудлын даруулга бүсийг тайлахаас өмнө түүнийг холбоосонд бэхэлсэн эсэх;
 - (2) хүн дээш өргөсөн тохиолдолд холбоосыг салгахаас өмнө түүнийг аюулгүйн оосорт бэхэлсэн, эсвэл суудлын даруулга бүс зүүлгэсэн эсэх;
 - (3) дүүжин тээвэрлэлт хийгдэж байгаа хүн ухаан алдсан, эсвэл ойлгоц хэвийн бус байгаагаас бусад тохиолдолд түүнд нисэх багийн гишүүд тухайн ажиллагаатай холбоотой нислэгийн хэвийн ба онцгой тохиолдлын журмыг танилцуулж зааварчлага өгсөн эсэх.
- (в) Агаарын хөлгийн дарга нь бэртэж гэмтсэн хүнийг аюулгүйн бүслүүр, торон дамнуургын тусламжтай дүүжин хэлбэрээр зөөвөрлөхдөө дараах нөхцлүүдийг хангасан байна:
- (1) тухайн хүнийг зөөвөрлөх зай нь:
 - (i) түүнийг илүү тохиромжтой тээврийн хэрэгсэлд шилжүүлэхэд,
 - (ii) аюулгүй буулт хийж, түүнийг нисдэг тэргэндээ шилжүүлэн оруулахад тус тус шаардлагатай хамгийн дөт замыг сонгох.
 - (2) ухаан алдсан, ойлгоц хэвийн бус байгаагаас бусад тохиолдолд түүнд нисэх багийн гишүүд тухайн ажиллагаатай холбоотой нислэгийн хэвийн ба онцгой тохиолдлын журмыг танилцуулж зааварчлага өгсөн эсэхийг.
- (г) Агаарын хөлгийн дарга нь нисдэг тэрэгнээс зориулалтын олсон татуурга ашиглан хүн буулгах ажиллагааг гүйцэтгэх үед дараах нөхцлийг хангана:
- тухайн дүүжин тээвэрлэлт хийгдэж байгаа хүн:

- (1) олсон татуургаар хүн тээвэрлэх сургалтыг амжилттай дүүргэсэн байх;
- (2) олсон татуургаар дүүжин тээвэрлэлт хийх ажиллагаатай холбоотой нислэгийн хэвийн ба онцгой тохиолдлын зааварчлагыг нисэх багийн гишүүдээс авсан байх;
- (3) суудлын даруулга бүсийг тайлахаас өмнө олсонд бэхлэгдсэн байна.

133.73. Багийн нэмэлт гишүүн

(a) Дүүжин тээвэрлэлт гүйцэтгэх агаарын хөлгийн дарга :

- (1) дараах үйлдлүүдийг өөрийн биеэр гүйцэтгэх боломжгүй тохиолдолд багийн нэмэлт гишүүнийг авч явна:
 - (i) хөдөлгөөнт зөөлөн холбоос ашиглах,
 - (ii) ачааг хянах, ажиглах,
 - (iii) ачааг салгах,
 - (iv) саадыг ажиглах,
 - (v) хүмүүсийг агаарын хөлгийн бүхээгт оруулах, бүхээгнээс гаргах.
- (2) багийн нэмэлт гишүүн гүйцэтгэх ажиллагаа болон тусгай даалгавартай хөөрөлтийн өмнө бүрэн танилцсан байна;
- (3) багийн нэмэлт гишүүн аюулгүйн бүсийг бүсэлсэн байх бөгөөд бүс нь онцгой тохиолдлын үед салгахад хялбар, санамсаргүй салахааргүй байна;
- (4) багийн нэмэлт гишүүн нь нисгэгчтэй хоёр талын харилцаатай байхын тулд холбооны төхөөрөмжөөр хангагдсан байна.

133.75. Нисэх багийн гишүүдийн бэлтгэл

(a) Нисэх багийн гишүүд тухайн гүйцэтгэх ажиллагаа, агаарын хөлөг болон тоног төхөөрөмжийн талаарх техникийн мэдлэг, чадвар болон нислэгийн хэвийн болон онцгой тохиолдлын үед маневрлах чадварыг шалгах шалгалтыг амжилттай өгч чадаагүй тохиолдолд агаарын тээвэрлэгч тэдэнд энэ дүрэмд заасан үйл ажиллагаануудад оролцох зөвшөөрөл өгөхгүй байвал зохино.

(б) Энэ зүйлийн (a)-д заасан шалгалтыг:

(1) дараах гэрчилгээ эзэмшигчид:

- (i) тухайн шалгалтыг авах эрх олгогдсон, ИНД-119-ийн дагуу гэрчилгээжсэн агаарын тээврийн үйл ажиллагаа эрхлэгч, эсвэл

(ii) ИНД-141-ийн дагуу гэрчилгээжсэн нисэхийн сургалтын байгууллага гүйцэтгэнэ;

- (2) нисэх багийн гишүүдийн тухайн ажиллагаанд шаардлагатай жолоодлогыг хийх чадварыг үнэлэх боломжтой агаарын хөлөг дээр шалгалтыг явуулна;
- (3) шалгалтыг тухайн ажиллагааг гүйцэтгэх нислэг үйлдэхээс өмнө 12 сарын дотор өгсөн байна.

(в) Энэ зүйлийн (а)-д заасан шалгалтанд дүүжин тээвэрлэлт гүйцэтгэх ажиллагааны үед үүсч болох бүх нислэгийн хэвийн ба онцгой тохиолдлын үеийн ажиллагааны нөхцөл байдлыг хамааруулна:

- (1) нислэгийн өмнөх бэлтгэл;
- (2) нисэх багийн менежмент;
- (3) буух талбайг тодорхойлох болон нисдэг тэргийг байрлуулах;
- (4) холбоо алдагдах;
- (5) аюулын үед тусламж үзүүлэх журам;
- (6) нисдэг тэрэгний анхааруулах аюулд орсон ажилтанд тусламж үзүүлэх журам;
- (7) нисдэг тэрэгний анхааруулах гэрлэн дохиолол;
- (8) хөдөлгүүрийн чадал алдагдах ;
- (9) цахилгааны дутагдал.

(г) Агаарын тээврийн үйлчилгээ эрхлэгч компани нь нислэгийн шалгалтын бүх материалыг доод тал нь 4 жил хадгална.

(д) Агаарын хөлгийн дарга нь хүн ам шигүү суурьшсан газар нутаг, хот, суурины дээгүүр болон ойр орчимд дүүжин тээвэрлэлт гүйцэтгэх дадлагын нислэг үйлдэж болохгүй.

В БҮЛЭГ -НӨӨЦ
Г БҮЛЭГ - НӨӨЦ
Д БҮЛЭГ- НӨӨЦ
Е БҮЛЭГ- ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

133.251. Зорилго

Энэ дүрмээр нисдэг тэргээр дүүжин нислэг үйлдэхэд ИНД-91 дүрмээр шаардсанаас нэмэлт хэрэглэл болон тоног төхөөрөмжүүдийг зохицуулахад оршино.

133.253. Ерөнхий зүйл.

(а) Нисдэг тэрэгний тоног төхөөрөмж нь энэ бүлэгт заасан дараах шаардлагуудыг хангаагүй тохиолдолд дүүжин тээвэрлэлт гүйцэтгэгч компани нислэгийг үйлдэж эхлэхгүй байх үүрэг хүлээнэ:

- (1) дараах журмуудад заасан техникийн үзүүлэлтүүд болон агаарын зайд хэрэглэх загвар стандартад нийцсэн байх, үүнд
 - (i) энэ бүлгийн заалтууд; эсвэл
 - (ii) тоног төхөөрөмжид тавигдах, тухайн дүүжин тээвэрлэлт хийх компани захирлын баталсан өөр техникийн үзүүлэлтүүд болон стандартууд орно;
- (2) Тоног төхөөрөмжүүд нь үйл ажиллагааны шаардлага, агаарын зайд хэрэглэх болон бусад холбогдох шаардлагын дагуу суурилуулагдсан байх;
- (3) Тэдгээр нь тухайн дүүжин тээвэрлэлтийн төрлийн нөхцөлд тохирсон үйл ажиллагаатай байх ба шаардлагатай тоо хэмжээг хангасан байна.

133.255. Дүүжин тээвэрлэлтэд ашиглах тоног төхөөрөмж

Нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх үйл ажиллагаа явуулдаг компани нь нисдэг тэрэгний тоног төхөөрөмжийн хувьд дараах хариуцлагыг хүлээнэ:

- (1) Дүүжин тээвэрлэлт гүйцэтгэх нисдэг тэрэг нь үйлдвэрлэгчээс нисдэг тэргэнд ашиглахыг зөвшөөрсөн ачааны дэгээ, эсвэл ижил төстэй хэрэгслээр тоноглогдсон байна. Эсвэл ИНД- 21 бүлэг С-д заасан загвар өөрчлөх заалтын дагуу зөвшөөрөгдөж суурилуулагдсан байна.
- (2) Дүүжин ачаа тээвэрлэх тоног төхөөрөмж нь:
 - (i) нисдэг тэргэнд гэмтэл учруулахааргүй, хэврэг бус, стандартын дагуу хийгдсэн, хэрэглэхэд тохиромжтой байна;
 - (ii) тухайн тоног төхөөрөмжөөр хүн зөөвөрлөх тохиолдолд тухайн жингээс 3.75 дахин хүнд ачааллыг даах чадвартай байна.

133.257. Түргэн салгах хэрэгсэл

(а) Нисдэг тэргээр дүүжин ачаа тээвэрлэх үйл ажиллагаа явуулдаг компаний нисдэг тэрэг дараах төхөөрөмжөөр тоноглогдсон байх хариуцлагыг хүлээнэ:

- (1) түргэн салгах цахилгаан төхөөрөмжөөр тоноглогдсон;
- (2) механик ажиллагаатай, эсвэл түргэн салгах тусгай цахилгаан төхөөрөмжөөр тоноглогдсон.

(б) Энэ зүйлийн (а)-д дурьдсан түргэн салгах хэрэгсэл нь нисдэг тэрэгний хамгийн их дүүжин ачаа даах даац хүртэл болон хамгийн их ачаа тээвэрлэж байх үед хэвийн ажиллагаатай байх үүргийг агаарын тээвэрлэгч хүлээнэ.

(в) Агаарын тээвэрлэгч нь түргэн салгах тоноглолын хувьд дараах үүргийг хүлээнэ:

(1) түргэн салгах төхөөрөмж нь үндсэн удирдлагатай байх ба тэр нь:

(i) аль нэг нисгэгчийн нислэгийн үндсэн хяналтын самбар дээр суурилагдсан, мөн

(ii) загвар хийц болон байрлалын хувьд нисгэгч онцгой тохиолдлын үед нислэгийн жолоодлогыг гүйцэтгэхэд саад болохгүйгээр суурилагдсан байна.

(2) нисэх багийн гишүүд шууд хүрч ажиллуулах боломжтой хоёрдогч удирдлагатай байх ёстой.

Ж БҮЛЭГ - ТЕХНИК ҮЙЛЧИЛГЭЭ

133.301. Зорилго

Энэ хэсэгт Монгол улсад бүртгэлтэй дүүжин тээвэрлэлт хийж буй нисдэг тэрэгний техник үйлчилгээний дүрмийг зохицуулахад оршино.

133.303. Техник үйлчилгээнд тавих шаардлага

Агаарын тээвэрлэгч нь нисдэг тэрэг болон энэ дүрмийн 133.255-ын (1)-р заалтанд дурьдсан ачааны дэгээ, болон бусад үүнтэй ижил төстэй хэрэгслүүдийн засвар үйлчилгээг ИНД-91 болон энэ дүрэмд заасны дагуу хийж гүйцэтгэх үүрэг хүлээнэ.

133.305. Техник үйлчилгээний ажилтан

Зохих сургалтанд хамрагдаж мэргэжлийн үнэмлэх авсан хүнийг техник үйлчилгээний ажилтнаар авах үүргийг агаарын тээвэрлэгч хүлээнэ.

133.307. Гадна ачааллах хэрэгсэл

(а) Агаарын тээвэрлэгч нь гадна ачааллах хэрэгслийг:

(1) ашиглалтын 50 цаг тутамд үзлэгт оруулж элэгдлийн шинж тэмдгийг шалгана;

(2) 12 сар эсвэл ашиглалтын 500 цагийн аль эхэлж болсон үед түүний зөвшөөрөгдсөн ачааллаас 1.25 дахин их ачааг туршилтын байдлаар ачаалж шалгана.

(б) Энэ зүйлийн (а)-д зааснаас гадна, агаарын тээвэрлэгч нь гадна ачааллах хэрэгслийн засвар үйлчилгээг дараах хуваарийн дагуу хийнэ:

(1) солих зайлшгүй шаардлагатай үед, үзлэг хийх тогтмол хуваарийн дагуу болон үйлдвэрлэгчийн засвар үйлчилгээ хийх гарын авлага зааврын дагуу тоног төхөөрөмжийн нислэгт тэнцэх чадварыг хангахын тулд техникийн үйлчилгээг хийнэ.

- (2) ИНД-91, ИНД-119-ийн дагуу батлагдсан техник үйлчилгээний хөтөлбөрийн дагуу засвар үйлчилгээний ажлыг хийнэ.